

Төсөл 2025.04.10

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... сарын-ны өдрийн
.... дугаар тогтоолын дүгээр хавсралт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ ЖУРАМ**

DRAFT

ГАРЧИГ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	2
ХОЁР.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР, ШААРДЛАГА.....	2
ГУРАВ.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ	3
ДӨРӨВ.БҮРТГЭЛТЭЙ БАЙХ ХУГАЦААНД БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ	6
ТАВ.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС	7
ЗУРГАА.ХАРИУЦЛАГА.....	8
ДОЛОО.БУСАД	8
Хавсралт 1 БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ	9
Хавсралт 2 ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
Хавсралт 3 ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧ БАНКНЫ МЭДЭГДЭЛ	14
Хавсралт 4 ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ 16	
Хавсралт 5 БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ	17

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар хадгаламжийн сертификатыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” эсхүл “МХБ” гэх)-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлага тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд хадгаламжийн сертификат гаргагчийн хүлээх үүргийг тодорхойлох, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банкны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан бусад журам, заавраар зохицуулна.
- 1.3. Энэхүү журмыг Биржийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хадгаламжийн сертификат гаргагч (цаашид “Банк” гэх), түүний ажилтан, эрх бүхий албан тушаалтнууд болон хадгаламжийн сертификат гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээд дагаж мөрдөнө.
- 1.4. Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд Бирж нь журмыг хүчин төгөлдөр хууль, журамд үндэслэн тайлбарлах эрхтэй байна.

Хоёр.Хадгаламжийн сертификат гаргагчид тавигдах шалгуур, шаардлага

- 2.1. Банк нь хадгаламжийн сертификатыг биржид бүртгүүлэхэд дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. Хорооны “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам” (Цаашид “Хорооны журам” гэх)-д заасан шаардлагыг бүрэн хангасан байх;
 - 2.1.2. энэхүү журмын хавсралтад заасан мэдээллийг агуулсан “хадгаламжийн сертификатын товч танилцуулга”-ыг бэлтгэн, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдээр баталгаажуулсан байх;
 - 2.1.3. хадгаламжийн сертификатын хугацаа нь 1 сараас багагүй, 12 сараас ихгүй байх;
 - 2.1.4. Хадгаламжийн сертификатын нэгжийн үнэ нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс багагүй байх.
- 2.2. Банк нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоох байгууллагаар “тогтвортой” ба түүнээс дээш түвшинтэй санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол энэхүү журмын 2.1.3-д заасан хугацааны дээд хязгаар хамаарахгүй.
- 2.3. Энэхүү журмын 2.1.2-т заасан Хадгаламжийн сертификатын товч танилцуулга нь хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад шаардлагатай хангалттай мэдээллийг агуулсан байх ба энэ журмын хавсралт 2-д тодорхойлсон мэдээллээр хязгаардагдахгүй болно.
- 2.4. Товч танилцуулгад дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 2.4.1. Хадгаламжийн сертификат гаргагчийн тухай ерөнхий мэдээлэл (хуулийн этгээдийн оноосон нэр, албан ёсны хаяг, холбоо барих мэдээлэл, үйл

- ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагдсан огноо, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн талаар, удирдлагын талаар, санхүүгийн үзүүлэлтүүд гэх мэт);
- 2.4.2. Хадгаламжийн сертификатын талаар мэдээлэл (нэрлэсэн үнэ, тоо хэмжээ, хүүгийн хувь хэмжээ, хадгаламжийн сертификатын нөхцөл, төрөл, хүү тооцох арга, өгөөж, хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг болон худалдан авагчдын шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлнэ гэж үзсэн бусад мэдээлэл);
- 2.4.3. Хөвөгч хүүтэй хадгаламжийн сертификат гаргах тохиолдолд хүүг шинэчлэх хугацаа, хүү тогтоох аргачлалын талаарх мэдээллийг танилцуулгад тодорхой тусгасан байх ба хүү тогтоох аргачлал нь бодитой, ил тод, хуульд нийцэх, зах зээлд суурилсан байх зарчмыг баримталсан байна.
- 2.4.4. Хүү тооцох аргачлал нь Монголбанк ба Хорооноос баталсан холбогдох заавар, аргачлалд нийцсэн байна.
- 2.4.5. Эргүүлэн дуудах нөхцөлтэй хадгаламжийн сертификат гаргах тохиолдолд эргүүлэн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулгад тусгана. Эргүүлэн дуудах үед авч хэрэгжүүлэх ажиллагааг энэхүү журмын 3.14 дэх заалтаар тодорхойлно.
- 2.4.6. Бусад чухал ач холбогдолтой мэдээлэл (мэргэжлийн зуучлагч, хөндлөнгийн шинжээч, дүгнэлт гаргасан бол дүгнэлт болон түүнийг гаргагчийн талаар, Банкны үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц үйл явдлын талаарх мэдээлэл, эрсдэлийн хүчин зүйлс гэх мэт).
- 2.4.7. Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:
“Хадгаламжийн сертификатыг “Монголын хөрөнгийн бирж” ХК болон Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг хадгаламжийн сертификатын эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү хадгаламжийн сертификатыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, хадгаламжийн сертификатын танилцуулга, хадгаламжийн сертификат гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”
- 2.5. Хадгаламжийн сертификатыг нэг удаа нийт дүнгээр бүртгүүлэн, цаашид нэг удаа эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн буюу транчтай гаргах тохиолдолд анхны нийлүүлэлтийг Хороо бүртгэх тухай шийдвэр гаргаснаас хойш 6 сарын дотор хийх ба үлдэх хэсгийг уг шийдвэрээс хойш 18 сарын дотор нийтэд санал болгосон байна.

**Гурав.Хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлт гаргах,
хүсэлтийг хянах, бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах**

- 3.1. Банк нь хадгаламжийн сертификат бүртгүүлэх хүсэлтээ Хороо болон Биржид нэгэн зэрэг гаргаж болох ба Биржид бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:
- 3.1.1. Хадгаламжийн сертификат бүртгүүлэх өргөдөл (Хавсралт 1-ийн дагуу);
- 3.1.2. Хорооны “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ын 3.2.2-3.2.3, 3.2.5-т заасан баримт бичгүүд;
- 3.1.3. Хадгаламжийн сертификат гаргагч буюу Банкны мэдэгдэл (Хавсралт 3-ын дагуу);
- 3.1.4. Энэхүү журмын хоёрдугаар бүлэгт заасан шалгуур, шаардлагыг хангаж байгаа болохыг нотлох бичиг баримт;
- 3.1.5. Энэхүү журмын 5.1.1-д заасан хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдлийг хянах үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- 3.1.6. Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт.

- 3.2. Хадгаламжийн сертификатыг нийтэд санал болгон, арилжих тохиолдолд Хорооноос тусгай зөвшөөрөл авсан, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд (цаашид “андеррайтер” гэх)-тэй гэрээ байгуулан, хамтран ажиллаж болно.
- 3.3. Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, агуулгын хувьд зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Бирж нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг Банкнаас шаардаж болно.
- 3.4. Бирж нь хадгаламжийн сертификат бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч бүрдэл бүрэн хангагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлийг баримтлан бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.5. Хадгаламжийн сертификатыг бүртгэх эсэх тухай Биржийн шийдвэр гарахаас өмнө Хороонд хүргүүлсэн болон энэхүү журмын хүрээнд Биржид ирүүлсэн материалд өөрчлөлт орсон, материал ирүүлснээс хойш Банкны үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулж буй зах зээлд хөрөнгө оруулагчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон бол уг мэдээлэл, баримт бичгийг тухай бүр Биржид ирүүлнэ.
- 3.6. Бирж нь банкны хадгаламжийн сертификатыг бүртгэх тухай шийдвэр гаргасан тохиолдолд Банктай “Бүртгэлийн гэрээ” (Хавсралт 5)-г байгуулах ба хадгаламжийн сертификат бүртгэсэн тухай шийдвэрийг Хороо, хадгаламжийн сертификат гаргагчид тус тус хүргүүлнэ.
- 3.7. Бирж нь Хадгаламжийн сертификат бүртгэсэн тухай Гүйцэтгэх захирлын тушаалын хуулбарыг мэдэгдэл (Хавсралт 4)-ийн хамт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.
- 3.8. Биржийн бүртгэсэн хадгаламжийн сертификатад Банкнаас ирүүлсэн саналыг харгалзан нэр, код олгох ба түүнд хадгаламжийн сертификатын хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөгдөх хугацаа зэргийг тусгах ба хэсэгчлэн гаргах тохиолдолд транч болгонд ялгах тэмдэглэгээ хийнэ.
- 3.9. Хадгаламжийн сертификат бүртгүүлэхээр болон бүртгүүлснээс хойш ирүүлэх баримт, бичгийг Монгол хэл дээр үйлдэх ба Банк, хадгаламжийн сертификат эзэмшигч, Бирж тус тус шаардлагатай гэж үзсэн тохиолдолд давхар Англи хэл дээр үйлдэж болно.
- 3.10. Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдлуудад хадгаламжийн сертификатыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган банканд энэ тухай бичгээр мэдэгдэнэ. Үүнд:
- 3.10.1. Банк өөрөө хүсэлт гаргасан;
- 3.10.2. Банк болон хадгаламжийн сертификат нь энэхүү журмаар тогтоосон шалгуур, шаардлагыг хангаагүй;
- 3.10.3. Хадгаламжийн сертификат бүртгүүлэх тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичигт хуурамч мэдээлэл агуулагдсан нь бүртгүүлэх өргөдлийг хянан шийдвэрлэх явцад тогтоогдсон.
- 3.11. Банк нь хадгаламжийн сертификат эзэмшигчийн хүсэлтээр хадгаламжийн сертификатыг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд биржийн бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг хадгаламжийн сертификатыг цуцалсан талаарх холбогдох баримтын хамт ирүүлнэ.
- 3.12. Банк нь өөрийн гаргасан хадгаламжийн сертификатыг бүхэлд нь эсхүл хэсэгчилсэн байдлаар эргүүлэн дуудсан буюу буцаан худалдаж авсан тохиолдолд уг худалдан авсан сертификатыг бүртгэлээс хасуулах эсхүл бүртгэлд өөрчлөлт оруулах тус тус хүсэлт гаргана.
- 3.13. Энэ журмын 3.12-т заасан үндэслэлээр бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг гаргахдаа энэ журмын 3.14-т заасан нөхцөл бүрдсэн болохыг нотлох баримтыг, бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийн хамт ирүүлнэ.

- 3.14. Эргүүлэн дуудах нөхцөлтэй хадгаламжийн сертификат гаргасан Банк нь Хадгаламжийн сертификатыг эргүүлэн дуудах буюу эргүүлэн худалдан авахад дараах нөхцөлүүдийг дагаж мөрдөнө. Үүнд:
- 3.14.1. Банк нь өөрийн гаргасан хадгаламжийн сертификатыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эргүүлэн худалдан авч болох бөгөөд сертификатыг нийтэд санал болгон гаргаснаас хойш хамгийн багадаа 1 сарын дараа эргүүлэн худалдаж авах саналыг гаргаж болно.
 - 3.14.2. Банк нь хадгаламжийн сертификатыг эргүүлэн худалдан авах саналыг гаргахдаа тухайн сертификатын эзэмшигчид буюу бүх хөрөнгө оруулагчдад ижил, тэгш хандах зарчмыг баримтална.
 - 3.14.3. Хөрөнгө оруулагчид эргүүлэн худалдан авах саналыг хүлээн авах эсхүл татгалзах эрхтэй байна.
 - 3.14.4. Хадгаламжийн сертификатыг эргүүлэн худалдан авах үнийг тогтоохдоо тухайн сертификатын Биржийн арилжаагаар арилжигдсан сүүлийн 6 сарын (хэрэв 6 сараас доош хугацаанд бүртгэлтэй байсан бол уг хугацааны) жигнэсэн дундаж ханшийг харгалзана.
 - 3.14.5. Эргүүлэн худалдаж авсан хадгаламжийн сертификатыг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь цуцалж, үүнтэй холбоотой гаргасан шийдвэр ба мэдээллийг нэн даруй Хороо, Монголбанк, Биржид мэдэгдэнэ.
 - 3.14.6. Эргүүлэн худалдан авах саналын талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэгэн зэрэг мэдээлнэ. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд Банк, Бирж, Хорооны албан ёсны цахим хуудас хамаарна.
 - 3.14.7. Энэ журмын 3.12.6-т заасан мэдээлэлд эргүүлэн худалдах эрхтэй хөрөнгө оруулагчдын нэрсийн жагсаалт гаргах өдөр, худалдан авах үнэ, тоо хэмжээ, захиалга хүлээн авах хугацаа буюу захиалгын эхлэх ба дуусах он сар, өдөр, цаг, худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр зэргийг зайлшгүй тусгасан байна.
 - 3.14.8. Эргүүлэн худалдах захиалгыг хүлээн авах хугацаа нь ажлын 3-аас дээш өдөр үргэлжилнэ.
 - 3.14.9. Хөрөнгө оруулагчдын эргүүлэн худалдах хадгаламжийн сертификатын тоо, хэмжээнд хязгаар тогтоож болно.
 - 3.14.10. Хадгаламжийн сертификатыг хэсэгчлэн худалдан авах үед хөрөнгө оруулагчийн худалдах захиалга банкны эргүүлэн худалдан авах саналаас давах тохиолдолд хувь тэнцүүлэн эргүүлэн худалдан авна.
 - 3.14.11. Хэрэв хөрөнгө оруулагчдаас захиалга хаагдах өдрийн захиалга хаагдах цагаас өмнө хадгаламжийн сертификатыг худалдах санал гаргасан бол уг саналыг хүлээн авч, төлбөр тооцоог бүрэн төлж дуусгаснаар, харин санал ирүүлээгүй тохиолдолд тухайн өдрөөр тасалбар болгон тус тус эргүүлэн худалдан авах ажиллагааг дуусгавар болгоно.
 - 3.14.12. Эргүүлэн худалдан авах ажиллагаа дууссаны дараа банк нь хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн худалдах санал, хүлээн авсан санал, худалдан авсан нийт үнийн дүн, шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг агуулсан тайлан, мэдээг Хороо ба Биржид хүргүүлнэ.
 - 3.14.13. Банк нь хадгаламжийн сертификатын төлбөр тооцоог тогтоосон хугацаанд хөрөнгө оруулагчдад төлөх үүрэгтэй.
 - 3.14.14. Банк нь хадгаламжийн сертификатын үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацаанд ногдох хүүгийн төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлнө. Хэтрүүлсэн хугацаанд тооцогдох

хүүгийн хэмжээ нь хадгаламжийн сертификатын танилцуулгад тусгагдсан хүүгийн хэмжээтэй тэнцүү байна.

- 3.15. Банк нь бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах бүрд энэ журмын 5.1.1-т заасан үйлчилгээний хөлсийг төлж, баримтыг хүсэлтэд хавсаргасан байна.
- 3.16. Бирж нь хадгаламжийн сертификатыг дараах тохиолдолд бүртгэлээс хасна. Үүнд:
- 3.16.1. Банк өөрөө хүсэлт гаргасан;
 - 3.16.2. Хорооны журмын 3.8.1-3.8.2, 3.8. дэх хэсэгт заасан аль нэг үндэслэлээр;
 - 3.16.3. Хорооны бүртгэлээс хасагдах шийдвэр гарсан;
 - 3.16.4. Дампуурлын тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу шүүх буюу эрх бүхий байгууллагын шийдвэр гарч, Банканд хэрэг гүйцэтгэгч, бүрэн эрхт төлөөлөгч томилсон ;
 - 3.16.5. Биржээс тогтоосон шалгуур шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон;
 - 3.16.6. Бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй;
 - 3.16.7. Хадгаламжийн сертификат бүртгүүлэх үед хуурамч баримт бичиг бүрдүүлсэн болох нь тогтоогдсон.
- 3.17. Банк нь хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:
- 3.17.1. Хадгаламжийн сертификатын бүртгэлээс хасуулах хүсэлт;
 - 3.17.2. Хадгаламжийн сертификатын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн талаарх тайлан;
 - 3.17.3. Энэ журмын 3.11; 3.13-т заасан тохиолдол, нөхцөл бүрдсэн ба тэдгээрт заасан ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн болохыг нотлох баримт.
- 3.18. Бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах асуудлыг Биржийн Бүртгэлийн хорооны хурлаар хэлэлцүүлэн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 3.19. Бирж хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт орсон, бүртгэлээс хасагдсан тохиолдолд зохих шийдвэрийг Хороо, хадгаламжийн сертификат гаргагч, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Дөрөв.Бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг

- 4.1. Банк нь Банкны тухай хууль болон Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, заавар, Биржтэй байгуулсан гэрээ, хадгаламжийн сертификат гаргагчийн мэдэгдэлд туссан хөрөнгө оруулагчдын болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүртгэлтэй байх хугацаанд бүрэн биелүүлж ажиллана.
- 4.2. Банк нь хадгаламжийн сертификатаа бүртгэлтэй байх хугацаанд Хорооны холбогдох журам болон энэхүү журамд заасан мэдээллийг зохих хугацаанд тогтмол ирүүлж, шалгуур, шаардлагыг хангаж ажиллана.
- 4.3. Банк нь мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хадгаламжийн сертификат эзэмшигчид, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Биржтэй харилцах этгээдтэй байх ба энэхүү үүргээ өөрөө эсхүл гуравдагч этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
- 4.4. Банк нь үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт мэдээлэл түгээх, тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэх тал дээр ижил, тэгш хандах зарчмыг баримтална.
- 4.5. Хөрөнгө оруулагчидтай харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллана.

- 4.6. Банк нь ханшид болон хадгаламжийн сертификатын төлбөр төлөлтөд нөлөө үзүүлэх мэдээллийг ажлын 1 өдөрт багтаан холбогдох хууль тогтоомж, Хорооны журам, энэхүү журамд заасны дагуу Биржид мэдэгдэх ба өөрийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх үүрэгтэй.
- 4.7. Банк нь жилийн болон хагас жилийн санхүүгийн тайландаа дараах мэдээллийг тусган жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Биржид тогтмол ирүүлнэ. Үүнд:
- 4.7.1. Нийт хадгалуулагчийн тоо, тэдгээрийн эзэмшиж буй хадгаламжийн сертификатын тоо;
- 4.7.2. Хадгаламжийн сертификатын хүү, дуусах хугацаа;
- 4.7.3. Үнэт цаасны зах зээлд арилжсан нийт сертификатын тоо, арилжааны дүн.
- 4.8. Монголбанкны зайны болон газар дээрх хяналт шалгалтаар банкны зохистой харьцаа алдагдсан, төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдсон бол Банк нь энэ талаар ажлын 2 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ.
- 4.9. Банк нь Биржтэй харилцах этгээдтэй байх ба уг томилогдсон этгээд нь бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байна.
- 4.10. Банкны гаргасан хадгаламжийн сертификат эсхүл аливаа өрийн хэрэгслийн төлбөр төлөгдөхгүй байх, төлбөрийн саатал үүсэх, төлбөр хугацаандаа төлөгдөхгүй байх нөхцөл бүрдсэн тохиолдолд зохих мэдээллийг Биржид ажлын нэг өдөрт багтаан мэдээлэх үүрэгтэй.
- 4.11. Хадгаламжийн сертификатыг эргүүлэн дуудах ажиллагааг хэрэгжүүлэх талаар болон хэрэгжүүлсэн талаарх тайлан, харилцагчийн хүсэлтээр цуцалсан гэх мэт мэдээллийг Биржид үйл явдал болсноос хойш ажлын 1 өдрийн дотор ирүүлнэ.
- 4.12. Банк нь Биржид бүртгүүлсэн хадгаламжийн сертификатын хугацаа дуусаж, нэрлэсэн дүн болон хуримтлагдсан хүүг хугацаанд нь төлсөн тохиолдолд энэ талаарх мэдээллийг Бирж болон бусад холбогдох байгууллагуудад хүргэх үүрэгтэй.
- 4.13. Хадгаламжийн сертификат гаргасан банк нь Монголбанкны “Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журам”-ын Хавсралт 1-д заасан заавал байлгах нөөцийн мэдээг тайлант хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан Биржид тогтмол ирүүлнэ.

Тав.Үйлчилгээний хөлс

- 5.1. Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 5.1.1. өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлс;
- 5.1.2. хадгаламжийн сертификатыг бүртгэх үйлчилгээний хөлс.
- 5.2. Банк нь өргөдөл хүлээн авч хянах үйлчилгээний хөлсийг Биржид хадгаламжийн сертификат бүртгүүлэх тухай өргөдөл гаргахдаа буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлж, энэ тухай баримтыг өргөдөлдөө хавсаргана.
- 5.3. Өргөдөл хүсэлтийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлсний хэмжээ нь шинээр болон нэмж хадгаламжийн сертификат бүртгүүлэх тухай өргөдөл гаргахад 2,000,000 (хоёр сая) төгрөг байна.
- 5.4. Энэ журмын 5.1.2-т заасан бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх нийт үнийн дүнгээс тооцох бөгөөд хэсэгчлэн буюу транчаар гаргах тохиолдолд тухай бүр арилжигдсан үнийн дүнгээс тооцон бүртгэх үйлчилгээний хөлсийг төлнө.
- 5.5. Бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг Биржид бүртгүүлэх хадгаламжийн сертификатын үнийн дүнгийн 0.01 хувиар тооцох ба 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгөөс багагүй, 50,000,000 (тавин сая) төгрөгөөс ихгүй байна.

Зургаа.Хариуцлага

- 6.1. Хадгаламжийн сертификатын мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч талууд хариуцна.
- 6.2. Хадгаламжийн сертификатын мэдээлэлд худал, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг хадгаламжийн сертификат гаргагч хариуцна.
- 6.3. Хадгаламжийн сертификат гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас хадгаламжийн сертификатын арилжааг зогсоох болон бусад арга хэмжээтэй холбогдон хөрөнгө оруулагч, хадгаламжийн сертификат эзэмшигчдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.

Долоо.Бусад

- 7.1. Банк нь Биржээс хадгаламжийн сертификаттай холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.
- 7.2. Банк хадгаламжийн сертификатыг барьцаалан зээл олгох харилцааг холбогдох хуулиар зохицуулна.
- 7.3. Банкнаас гаргасан хадгаламжийн сертификатын заавал байлгах нөөцийн шаардлагыг Төв банкны холбогдох журмаар зохицуулна.

---oOo---

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ
(Хадгаламжийн сертификат бүртгүүлэхэд)

Хэнд: “Монголын хөрөнгийн бирж” ХК,
Бүртгэлийн алба

Огноо:.....

Эрхэм Танаа,

Бид [Хадгаламжийн сертификат гаргагч хуулийн этгээд, түүнийг төлөөлж] энэхүү маягтын-т тусгасан хадгаламжийн сертификатыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам”-ын дагуу бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авахаар энэхүү өргөдлийг гаргаж байна.

1. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ		
Хуулийн этгээдийн нэр		
Хуулийн этгээдийн хэлбэр	○ <i>Нээлттэй хувьцаат компани</i>	
	○ <i>Хаалттай хувьцаат компани</i>	
	○ <i>Дотоодын хөрөнгө оруулалттай</i>	
Хөрөнгө оруулалтын хэлбэр	○ <i>Гадаадын хөрөнгө оруулалттай</i>	
Үүсгэн байгуулагдсан огноо		
Улсын бүртгэлийн дугаар		
Регистрийн дугаар		
Үйл ажиллагааны чиглэл (чиглэл тус бүрийг бичнэ)		
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч этгээд бол товч мэдээлэл		
Компанийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл (5 буюу түүнээс дээш хувь эзэмшигч)	<i>Овог, нэр</i>	
	<i>Иргэний харьяалал</i>	
	<i>Регистр /үнэмлэх/-ийн дугаар</i>	
	<i>Эзэмшиж буй хувь, хэмжээ</i>	
	<i>Холбоо барих мэдээлэл</i>	
Албан ёсны хаяг	<i>Аймаг /хот</i>	
	<i>Сум /Дүүрэг</i>	
	<i>Баг /Хороо</i>	
	<i>Гудамж / Байр</i>	
	<i>Тоот</i>	
Албан ёсны цахим хуудас болон цахим шуудангийн хаяг		
Холбоо барих утас		
Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудан		

Арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагчийн үнэт цаас бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл:* /Хэрэв тийм бол бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх бүртгэлтэй үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх талаар бичнэ/	
Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эсэх:*	
2. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН МЭДЭЭЛЭЛ <i>(Хадгаламжийн сертификат нь хэсэгчилсэн буюу транчтай бол тус бүрээр мэдээллийг оруулна)</i>	
Хадгаламжийн сертификатын нэр	
Үнэт цаасны код /үсгэн ба тоон/: /Шинээр хадгаламжийн сертификат бүртгүүлэх компани нь үнэт цаасанд олгох үсгэн кодын саналаа бичнэ/	
Хадгаламжийн сертификатын төрөл / нөхцөл	☐ Хэсэгчилсэн/транчтай ☐ Хямдруулсан үнэтэй ☐ Хөвөгч хүүтэй ☐ Эргэн дуудах нөхцөлтэй ☐ Тогтол хүүтэй ☐ Бусад нөхцөл (.....)
	Нэмэлт тайлбар:
Тоо ширхэг	
Нэрлэсэн үнэ	
Үнийн дүн	
Хүү	
Хүү төлөх давтамж, хугацаа	
Үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа	
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	
Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаарх товч мэдээлэл	
Хадгаламжийн сертификатыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа	
Зээлжих зэрэглэлтэй бол түүний талаар	

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч банк бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн
сертификат гаргагч

“.....”К-ийн

.....дарга

.....

Гарын үсэг: (Тамга/тэмдэг)

Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн
сертификат гаргагч

“.....”К-ийн

..... дарга

Гарын үсэг: (Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог, нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

---oOo---

DRAFT

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

/..... Банкнаас гаргаж буй Хадгаламжийн сертификат/

Огноо:/...../..... (он,сар,өдөр)

Энэхүү Товч танилцуулга нь нийтэд санал болгон хадгаламжийн сертификат гаргах Банк, түүний гаргаж буй хадгаламжийн сертификатын талаар, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа гэх мэт хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

I. Хадгаламжийн сертификат гаргагчийн мэдээлэл

- 1.1 Хадгаламжийн сертификат гаргагч банкны нэр;
- 1.2 Хуулийн этгээдийн хэлбэр (ХК, ХХК);
- 1.3 Хөрөнгө оруулалтын хэлбэр (Гадаадын, дотоодын хөрөнгө оруулалттай);
- 1.4 Үүсгэн байгуулагдсан огноо;
- 1.5 Улсын бүртгэлийн дугаар;
- 1.6 Үйл ажиллагааны чиглэл (чиглэл тус бүрийг бичнэ);
- 1.7 Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч бол дэлгэрэнгүй мэдээлэл;
- 1.8 Банкны эзэмшигчдийн талаар;
- 1.9 Банкны удирдлагын талаар;
- 1.10 Банкны санхүүгийн ерөнхий үзүүлэлт (Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан ашиг/алдагдал, Зээлийн цэвэр дүн, Нийт зээл, Чанаргүй зээл, Зээлийн эрсдэлийн сан, Харилцах, Хадгаламж гэх зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг сүүлд гаргасан санхүүгийн тайлангийн дүнгээр бичнэ)
- 1.11 Банкны богино болон урт хугацааны санхүүгийн эх үүсвэрийн мэдээлэл, товч тайлбар
Зээлжих зэрэглэл, түүнийг тогтоосон этгээд (зэрэглэл тогтоосон бол);
- 1.12 Өмнө гаргасан хугацаа дуусаагүй хадгаламжийн сертификатын нийт үнийн дүн, түүний төлөлтөд төлбөрийн саатал үүссэн эсэх эсхүл хугацаанд нь төлөөгүй төлбөрийн үлдэгдэл байгаа эсэх талаарх мэдээлэл;
- 1.13 Заавал байлгах нөөц болон бусад зохистой харьцааны үзүүлэлтийг хангасан байдлын болон цаашид тогтмол хангах эсэх талаар.
- 1.14 Шаардлагатай гэж үзсэн бусад.

II. Хадгаламжийн сертификатын мэдээлэл

- 2.1 Хадгаламжийн сертификат гаргахтай холбоотойгоор гаргасан Банкны эрх бүхий этгээдийн шийдвэр, түүнийг баталсан огноо, шийдвэрийн дугаар;
- 2.2 Хадгаламжийн сертификатын нэр, код;
- 2.2 Нэгжийн үнэ;
- 2.3 Тоо ширхэг;
- 2.4 Хадгаламжийн сертификатын нийт үнийн дүн;
- 2.5 Хүүгийн хэмжээ, хүүгийн төрөл (тогтмол, хөвөгч, тэг хүү буюу хямдруулалттай гэх мэт);

- 2.6 Хүү төлөх давтамж, хугацаа (хугацааны эцэст, улирал тутам, сараар, жил тутам);
- 2.7 Бусад нөхцөл (хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авах/худалдах нөхцөлтэй эсэх, хугацаанаас өмнө цуцалбал торгууль төлөх эсэх гэх мэт);
- 2.8 Хүүгийн орлогын ба бусад төрлийн татварын дүн;
- 2.9 Хугацааны эцэст төлөгдөх дүн;
- 2.10 Өгөөжийн хэмжээ;
- 2.11 Хадгаламжийн сертификатыг анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр;
- 2.12 Анхдагч зах зээлд арилжих огноо;
- 2.13 Татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө;
- 2.14 Хадгаламжийн сертификатыг тодорхой үе шаттайгаар хэсэгчлэн буюу транч байдлаар гаргах бол дэлгэрэнгүй мэдээлэл;
- 2.15 Эрсдэлийн хүчин зүйлс (хадгаламжийн сертификат эзэмшигчдэд тулгарч болох сертификаттай холбоотой бүх эрсдэлийг томоос бага руу эрэмбэлэн, дэлгэрэнгүй тайлбарлана).
- 2.16 Эрсдэлийн үнэлгээ (байгаа бол)
- 2.17 Хадгаламж сертификат эзэмшигчдийн эрх, үүрэг
- 2.16 Андеррайтер, хадгаламжийн сертификат гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бол түүнтэй байгуулсан гэрээ, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага;
- 2.17 Төлбөрийн саатал үүсэж, тогтоосон хугацаанд хөрөнгө оруулагчдад төлбөр төлөөгүй бол банк нь хугацаа хэтэрсэн хоног тутам алданги тооцох эсхүл хадгаламжийн сертификатын хүүтэй дүйцэх төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлөх эсэх талаар
- 2.18 Шаардлагатай гэж үзсэн бусад.

III. Хадгаламжийн сертификат гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдийн мэдээлэл (Зөвхөн уг ажиллагаанд оролцсон этгээдийн мэдээллийг бичнэ)

- 3.1 Андеррайтер буюу мэргэжлийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн мэдээлэл, түүний дүгнэлт;
- 3.2 Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл, түүний дүгнэлт;
- 3.3 Аудитын Байгууллагын мэдээлэл, тайлан дүгнэлт;
- 3.4 Зэрэглэл тогтоох эсхүл үнэлгээ хийсэн этгээдийн мэдээлэл, дүгнэлт.

Энэхүү танилцуулга, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргагч банк бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг Хадгаламжийн сертификатын товч танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

---oOo---

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧ БАНКНЫ МЭДЭГДЭЛ

Огноо

1. Хадгаламжийн сертификат гаргагч.....[Хадгаламжийн сертификат гаргагч банк, түүнийг төлөөлж] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна. Үүнд:

- 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хадгаламжийн сертификатыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулах, хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
- 1.2. Хадгаламжийн сертификат бүртгүүлэхтэй холбоотой Биржийн “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам”-д тусгагдсан хадгаламжийн сертификат гаргагч болон хадгаламжийн сертификатад тавигдах нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.
- 1.3. “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг өргөдлийн хамт хүргүүлж байгаа баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
- 1.4. Хадгаламжийн сертификат бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахтай холбоотойгоор хадгаламжийн сертификат гаргагчийн өргөдөлд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болно. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд Биржид нэн даруй мэдээлнэ.
- 1.5. Энэхүү мэдэгдэлд тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, худал, ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг бид бүрэн хариуцна.

2. Хадгаламжийн сертификат гаргагч Банк нь Биржид бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлэхийг мэдэгдэж байна. Үүнд:

- 2.1. Манай хадгаламжийн сертификат Биржид бүртгэгдсэн нөхцөлд Биржийн “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам” болон холбогдох бусад журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
- 2.2. Өргөдлийг хүлээн авч, хадгаламжийн сертификатыг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд зохих хууль, журмын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржид хүргүүлнэ.
- 2.3. Хадгаламжийн сертификат гаргагч нь “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд хадгаламжийн сертификат гаргагчийн хадгаламжийн сертификат нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч байна.

3. Дараах зүйлсийг Биржийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ. Үүнд:

- 3.1. Биржийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл, баримт;
- 3.2. Биржийн зүгээс “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардсан тайлбар, баримт бичиг, мэдээлэл;
- 3.3. Холбогдох хууль, журмын дагуу Хороо болон хөрөнгө оруулагчдад нэгэн зэрэг хүргэсэн мэдээлэл;
- 3.4. Өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх.
4. Энэ журамд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтны шалгуур, нөхцөлийг хангаж байгааг мэдэгдэж байна.
5. Бүртгүүлэх хадгаламжийн сертификат нь чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй болно.
5. Би жилийн хугацаанд хадгаламжийн сертификат гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бөгөөд миний албан тушаал, холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.
6. Хадгаламжийн сертификат бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материал, хадгаламжийн сертификатын товч танилцуулгад орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.
7. Энэхүү мэдэгдлийн 3, 4-т тусгасан мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй, буруу ташаа мэдээлэл хүргүүлсэн нь нотлогдвол түүнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

II. Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс, шимтгэлтэй холбоотой мэдэгдэл:

1. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон тохиолдолд журамд заасан хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр хадгаламжийн сертификатыг бүртгэх үйлчилгээний хөлсийг мөн арилжааны шимтгэлийг Биржид төлөхөө мэдэгдэж байна.

Мэдэгдэл гаргасан:

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн сертификат
сертификат гаргагч

“.....”К-ийн

..... дарга

Гарын үсэг: (Тамга/тэмдэг)

Баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн
гаргагч

“.....”К-ийн

..... дарга

Гарын үсэг: (Тамга/тэмдэг)

---oOo---

**ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд:

№.....

Огноо:.....

ҮЗҮҮЛЭЛТ	ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ БҮРТГҮҮЛЭХ	ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ	ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:			
Үндэслэл:			
Санхүүгийн хэрэгсэл			
Хадгаламжийн сертификатын нэр:			
Хадгаламжийн сертификатын код: /үсгэн, тоон/			
Хадгаламжийн сертификатын төрөл:			
Хадгаламжийн сертификатын хэлбэр: /биет, биет бус/			
Нийт хадгаламжийн сертификатын тоо: /ширхэг/			
Хадгаламжийн сертификатын нэрлэсэн үнэ: /төгрөг/			
Хадгаламжийн сертификатын нийт үнийн дүн: /төгрөг/			
Хадгаламжийн сертификатын нөхцөл:			
Хадгаламжийн сертификатын хүү/ өгөөжийн хувь хэмжээ:			
Хадгаламжийн сертификатын хугацаа:			
Бусад:			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

---oOo---

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ
/Хадгаламжийн сертификат/

20.. оны ... сарын ...-ны өдөр

№...

Улаанбаатар хот

Нэг талаас: “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлж Хяналт, зохицуулалтын газрын захирал,

Нөгөө талаас: “.....” ХК, ХХК (цаашид “Хадгаламжийн сертификат гаргагч” гэх), түүнийг төлөөлж нар (хамтад нь “Талууд” гэх),

Нэг. Гэрээний нөхцөл

Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд Хадгаламжийн сертификат гаргагчийн хадгаламжийн сертификатыг Биржид бүртгэх, арилжих, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав. Үүнд:

- 1.1. Бирж нь Хадгаламжийн сертификат гаргагчийн гаргасан /...../ төгрөгийн нэрлэсэн үнэ, хямдруулсан үнэ бүхий /...../ ширхэг компанийн хадгаламжийн сертификатыг Хадгаламжийн сертификатын бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн, хадгаламжийн сертификатын арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Хадгаламжийн сертификат гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-аар олгогдсон эрхийг эдлэх ба мөн журамд заасан үүргийг хэрэгжүүлж ажиллана.
- 1.3. Хадгаламжийн сертификат гаргагч нь арилжигдсан хадгаламжийн сертификатын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлж барагдуулна.
- 1.4. Хадгаламжийн сертификат гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангаж, хадгаламжийн сертификат эзэмшигчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.
- 1.5. Бирж нь Хадгаламжийн сертификат гаргагчийн хадгаламжийн сертификатын төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авхуулахаар холбогдох эрх бүхий байгууллагуудад хандах эрхтэй.
- 1.6. Хадгаламжийн сертификат гаргагч нь хадгаламжийн сертификатын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн “Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам”-ын-т заасны дагуу бүртгэх үйлчилгээний хөлсийг тооцон Биржийн дансанд шилжүүлнэ. Хадгаламжийн сертификат гаргагч нь тус хугацаанд бүртгэх үйлчилгээний хөлсийг төлөөгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Биржид төлнө.
- 1.7. Хадгаламжийн сертификат гаргагч нь Биржийн “Арилжааны журам”-ын ...-д заасны дагуу хадгаламжийн сертификатыг анхдагч зах зээл дээр арилжаалсан үнийн дүнгээс ...хувиар тооцон арилжааны шимтгэлийг Биржид төлнө.
- 1.8. Хадгаламжийн сертификат гаргагч нь хадгаламжийн сертификатыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг арилжааг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Биржид албан бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлд дараах мэдээллийг хавсаргана. Үүнд:
 - 1.8.1. хадгаламжийн сертификатын нөхцөл;
 - 1.8.2. анхдагч зах зээлийн арилжааны захиалга авах нөхцөл: захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа, санал болгох арга хэлбэр г.м;

- 1.8.3. хадгаламжийн сертификатыг үе шаттай /транч/ гаргах тохиолдолд: сүүлийн улирлын санхүүгийн тайлан, төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл, хадгаламжийн сертификат гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан.
- 1.9. Хадгаламжийн сертификат гаргагч нь дараах мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт тухайн үйл явдал болсноос хойш ажлын 3 өдрийн дотор Биржид ирүүлнэ. Үүнд:
- 1.9.1. хадгаламжийн сертификатын үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлт хийгдсэн тухай;
- 1.9.2. төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тухай, хадгаламжийн сертификатын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
- 1.9.3. бүртгэлтэй хадгаламжийн сертификаттай холбоотой аливаа өөрчлөлт (хадгаламжийн сертификатын нөхцөл, төлбөрийн хуваарь, нийтэд санал болгох хугацаа өөрчлөгдөх г.м)-ийн талаарх мэдээлэл;
- 1.9.4. хадгаламжийн сертификат эзэмшигч, хөрөнгө оруулагчдын шийдвэр, хадгаламжийн сертификат гаргагчийн үйл ажиллагаа, хадгаламжийн сертификатын үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллүүд.

Хоёр. Хариуцлага

- 2.1. Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны болон Биржийн холбогдох дүрэм, журам, заавар, энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс аливаа этгээдэд учирсан хохирлыг Хадгаламжийн сертификат гаргагч, түүний холбогдох албан тушаалтан бүрэн хариуцна.
- 2.2. Хадгаламжийн сертификат гаргагч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авна.
- 2.3. Брокер болон Хадгаламжийн сертификат гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан бусад этгээдэд учирсан хохирлыг Бирж хариуцахгүй.

Гурав. Маргаан шийдвэрлэх

- 3.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргаан, гомдлын шаардлага зэргийг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
- 3.2. Хэрэв талууд гэрээтэй холбогдох маргааныг энэхүү гэрээний 3.1-т зааснаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 4.2. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчлэх ба хадгаламжийн сертификатын төлбөр бүрэн төлөгдөж, гэрээний үүргийн биелэлтийг хангаснаар дуусгавар болно.
- 4.3. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 4.4. Гэрээг цуцлах тухай саналыг ажлын 5 өдрийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Биржийг төлөөлж:

.....
.....

Хадгаламжийн сертификат гаргагчийг
төлөөлж:

“.....” ХК, ХХК-ийн
.....

---oOo---